

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ  
ДОТООД АУДИТЫН ТАСГИЙН 2024 ОНЫ 02 ДУГААР УЛИРЛЫН ХИЙСЭН  
АЖЛЫН ИЛТГЭХ ХУУДАС**

2024.07.10

Улаанбаатар хот

**Нэг.Ерөнхий зүйл :**

Тус тасаг нь Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний стандарт, нийгмийн даатгалын ажилтны ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон үйлчилгээний соёл сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллалаа.

Тасаг болон байцаагч тус бүр 2023 оны ажлаа дүгнэн, 2024 онд хийх ажлыг жил улирлаар төлөвлөн төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулан, ололт амжилтийг дүгнэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын ажилтны ёс зүйг өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон зөрчил дутагдал гаргалгүй, иргэд даатгуулагч, ажил олгогчдын эрэлт хүсэлтийг хүлээн авч, хуулийн хүрээнд шалган зааварчилж гомдол чирэгдэл гаргалгүй хугацаанд барагдууллаа.

**Хоёр: 2024 онд хийхээр төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн талаар:**

2024 оны эхний хагас жилийн байдлаар нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, хөдөлмөрийн хөлсний сан түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлсон байдал, нийгмийн даатгалын шимтгэл хураамжийн ногдуулалт, төлөлт, тайланг хугацаанд нь тушааж буй байдлыг нийт 75 ажил олгогчийн 282 даатгуулагчийг хамруулан, улсын байцаагчийн актаар 44 ажил олгогчид 1324,8 сая төгрөгийн хөдөлмөр хөлс түүнтэй адилтгах орлогын төлбөр зөрчлийн дүнгээс 169,1 сая төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлж, түүнээс 49,5 сая төгрөгийн алданги ногдуулж нийт 218,6 сая төгрөгийн төлбөр зөрчлийн дүнг 100% хувь барагдуулаад байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлдөггүй, тайланг хугацаандаа тайлагнаагүй даатгуулагчийн эрх ашгийг хохироосон нийт 32 ажил олгогч байгууллагын захирал, нягтлан бодогчдод Зөрчилын тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.2, 10.17.4, 10.17.8, 10.17.9 заалтын дагуу шийтгэврийн хуудсаар 16,5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан.

Дотоодын хяналт шалгалт хийх ажлын хүрээнд 2024 оны эхний хагас байдлаар шинээр тогтоогдсон 1178 өндөр насны тэтгэвэр авагчийн 1403,2 сая төгрөг, тэжээгчээ алдсаны 30 тэтгэвэр авагчийн 17,6 сая төгрөг, тахир дутуугийн 98 тэтгэвэр авагчийн 58,9 сая төгрөг нийт 1306 тэтгэвэр авагчийн 1 479,8 сая төгрөгийн тэтгэврийн хувийн хэргийг шалгав. Ажилласан жилийн нэмэгдэл 373 тэтгэвэр авагч хийлгэсэн мөн Хөдөлмөрийн чадвар алдсан 250 тэтгэврийн сунгалт хийлгэсэн өөрчлөлтийг тухай бүр нь хянаж Sikos програмд шийдвэрлэж ажилласан.

Мөн ХЧТА -4426 даатгуулагчийн 1 843,6 сая төгрөгийн тэтгэмж, жирэмсний болон амаржсаны 999 даатгуулагчийн 3 589,6 сая төгрөгийн, ҮОМШӨ-н ХЧТА-92 даатгуулагчийн 157,4 сая төгрөгийн нийт 5 517 даатгуулагчийн эмнэлгийн хуудасыг шалгаж 5 590,6 сая төгрөгийн тэтгэмжийг хянаж олгуулав.

Тайлант хугацаанд 290 даатгуулагчдын 580,0 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийн олголт бодолт болон ажилгүйдлийн даатгалын сангаас 1160 хүнд олгосон 4 116,08 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжинд шалгаснаас ажилгүйдлийн тэтгэмж авах хугацаандаа ажил хийсэн, цалин буруу шивсэн, цалинг нэгдсэн мэдээллийн санд шивээгүй бодолт хийсэн, ажилласан жилийг нотлох баримт дутуу зэрэг зөрчлийг байсныг хариуцсан байцаагчаар тухай бүр нь засаж залруулав.

Дотоод хяналт шалгалтаар илрүүлсэн төлбөр зөрчил 2024 оны эхний хагас жилийн байдлаар:

- Тэтгэмжийн даатгалын санд- 59 даатгуулагчийн 21,1 сая төгрөгийн төлбөрөөс 16,1 сая төгрөгийг төлүүлсэн.
- Тэтгэврийн даатгалын санд 2024 оны эхний хагас жилийн байдлаар шинээр 8 тэтгэвэр авагчтай холбоотой 245,6 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 70,2 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж ажиллаа. Нийт 113 иргэнтэй холбоотой 542,3 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс дүнгээс 147,6 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж, барагдаагүй төлбөр 394,7 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, мөн хуулийн дагуу 50% хүртэлх хэмжээгээр суутган төлүүлж ажилласан.

Дээд газрын болон хөндлөнгийн хяналт шалгалтаар нийт 90 даатгуулагчтай холбоотой 50,3 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 34,9 сая төгрөгийг барагдуулж 15,3 сая төгрөгийг төлбөр зөрчлийг барагдуулах шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байна.

- Үүнд: Тэтгэвэр 71 даатгуулагчийн 44,1 сая төгрөгийн төлбөрөөс 34,4 сая төгрөгийн зөрчлийг барагдуулж 9,6 сая төгрөг үлдсэн.
- Тэтгэмж 18 даатгуулагчтай холбоотой 1,5 сая төгрөгийн зөрчлөөс 200,6 мянган төгрөгийг барагдуулсан.
- Ажилгүйдлийн тэтгэмж 1 даатгуулагчтай холбоотой 3,1 сая төгрөгийг барагдуулах ажиллагаа хийгдэж даатгуулагч Баянжаргал нь Монгол улсад байхгүй хамаарал бүхий этгээд олдохгүй байгаа тул эрэн сурвалжлуулахаар хандаад байна.

Эхний хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын сангийн 87 мэдээлэл, газрын үйл ажиллагааны 92 мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жил бүрээр гэсэн давтамжтайгаар үнэн зөв, хуулийн хугацаанд бүрэн байршуулж байна. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт тус тус цахимаар дараа сарын 8-ны дотор хавсралтанд заасан маягтын дагуу байршуулж байгаад хяналт тавьж ажиллаж байна.

Дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдсан нийт 3105 иргэн байгаа нь нийт хүн амын 2.13 хувийг эзэлж байна. Иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгааныг судалж үзэхэд мэдрэл, гэмтэл, сэтгэц, нүд, сонсголын эрхтний эмгэг давамгайлж байгаа бөгөөд зүрх судасны эмгэг, хавдрын өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдах

тохиолдолд мөн тэргүүлэх байранд хэвээр байна. ЭХМК-ын хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон, сунгуулсан нийт иргэдийн 15.96%-ийг мэд-рэлийн, 14.3%-ийг гэмтлийн, 13.1%-ийг сэтгэцийн, 11.2%-ийг нүдний, 10.5%-ийг сонсголын эмгэгүүд эзэлж байгаа юм. ЭМЯ-наас санаачлан зохион байгуулсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээний ажлын үр дүнд тус дүүргийн хэмжээнд хавдрын өвчлөлөөр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэдийн тоо өмнөх 2023 онтой харьцуулахад нэмэгдсэн боловч, 2024 оны эхний хагас жилийн байдлаар хавдрын өвчлөл буурсан байна. Хөдөлмөрийн чадвар алдалтаа тогтоолгосон, сунгуулсан иргэдийн өвчлөлийн шалтгааныг судлаж үзэхэд иргэдийн амьдралын буруу хэв маяг, буруу хооллолт, эрүүл мэндийн талаар мэдлэг дутуу, эрүүл мэнддээ анхаарал хандуулахгүй байгаа нь өвчлөл үүсэх улмаар хөдөлмөрийн чадвар алдалт үүсэх нөхцөл шалтгаан болж байна.

Тайлант хугацаанд тус газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нийт 20 удаа хуралдаж, 849 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэн шийдвэрлээд байна, үүнээс 594 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, жуагсаалтын шаардлагад нийцсэн 173 иргэнд өвчний явц, шинжилгээ, үзлэг, өвчтөнд илэрч буй зовиур өөрчлөлтийг үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож, биеийн байдал сайжирсан, эдгэрсэн, хяналтын хугацаа дууссан шалтгаанаар 66 иргэний хувь, хугацааг цуцлаад байна.

Тус дүүргийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалд хамрагдсан байдалд үзлэг явуулах, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, иргэдийн нийгмийн баталгааг хангах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, хамрах хүрээг өргөтгөх зорилтын дагуу ажиллаж тэдгээрийг шинээр хамруулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

### **Гурав: Бусад**

1. 2024.01.11-ны өдрийн Газрын даргын баталсан №01 тоот “Тэтгэврийн хувийн хэргийн тооллого, олголтыг тулган шалгах” ажлын удирдамж дагуу 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 2023 оны 12 дугаар сарын 31-ныг дуустлах хугацааны 23513 тэтгэвэр авагчийн хувийн хэргийн иж бүрэн байдал, тэтгэвэр олголт, тогтоолт, хөдөлгөөн бүрийг мэдээллийн бааз, хувийн хэрэгтээ тулган шалгаллаа.

Шалгалтаар тэтгэвэр олголтын массивын нийт 23513-с тайлант оны 22486 идэвхтэй тэтгэвэр авагчийн , 152 шилжиж явсан, 562 нас барсан, 313 зогсоогдсон тэтгэвэр авагчийн нийт 1027 тэтгэвэр авагчийн хөдөлгөөн бүрээр хэвлэн тулган шалгаж тооллого явуулсан дутуу хувийн хэрэг байхгүй. Илүү олгосон 20 тэтгэвэр авагчийн 6 057 105 төгрөгийн төлбөр зөрчлийг төлүүлэхээр, дутуу олгосон 33 тэтгэвэр авагчийн 5 649 776 төгрөгийн зөрчлийг олгуулахаар Үйлчилгээний тасгийн дарга Ч.Эрдэнэчимэгт жагсаалтыг өгсөн.

2. 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн Газрын даргын баталсан №02 тоот “Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг шалгах ажлын удирдамж ”-н дагуу шалгасан. Нийт ажил олгогчийн массив- 10390, үйл ажиллагаа зогссон -3016, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан 7374 аж ахуй нэгж шалгасан.

- Байгууллагын тамгагүй-342,
- Байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэггүй-341,
- Дутуу тайлан-46,
- Нөхөнгийн тайлангийн албан бичиг баримт, цалин залруулгын баримт, карт зэрэг тайланд хавсаргаагүй-70,
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн төрөл буруу тайлагнасан-845 зөрчлийг шийдвэрлүүлэхээр Орлого шимтгэлийн тасгийн дарга Ё.Уранцэцэгт тоо дүнг өгсөн.

3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн 03/26, 2/520 тоот “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” албан тоот, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль”-ийн хэрэгжилт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт заасан нөхцлөөр 2021 оныг хүртэлх хугацаанд шинээр тогтоолгосон өндөр нас авагчийн тэтгэврийн хувийн хэрэгт бүрдүүлсэн хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, тушаал, архивын лавлагаа, шүүхийн шийдвэр болон ажилласан жил нөхөн тооцуулахаар бүрдүүлсэн баримт анхан шатны баримт, цалингийн лавлагааны үндэслэл зэргийг архивын хянан шалгаж баталгаажуулах, илэрсэн дутагдлыг арилгаж ажиллаж байна. Шалгалтаар 1396 өндөр насны тэтгэвэр авагчийн тэтгэврийг шалгаж 53 тэтгэвэр авагчтай холбоотой 975,8 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 49 тэтгэвэр авагчийн 877,3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг нотлон баталгаажуулж, 550,3 сая төгрөгийг төлүүлж үлдэгдэл 153,1 сая төгрөгийн төлбөрийг суутган тооцож барагдуулах ажил хийгдэж байна. Мөн 4 тэтгэвэр авагчийн 98,5 сая төгрөгийн төлбөр нотлогдоогүй, улсын байцаагчийн акттай 1 тэтгэвэр авагчийн 14,7 сая нийт 4 иргэний 113,2 сая төгрөгийн төлбөр зөрчлийг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

4. 2024 оны нийгмийн даатгалын хяналт шалгалтын тайлан дүн мэдээг улирал бүр заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт гарган өгч баталгаажуулж ажилласан.

5. 2024 онд ажил хөдөлмөр эрхлээгүй, хувиараа хөдөлмөр эрхлэгч 151 иргэдийг сайн дурын даатгалд хамруулсан, шинээр 20 аж ахуй нэгж байгууллага, албан журмын даатгуулагч 54 хамруулсан .

1) Чойжин прайм ХХК-8350256

2) Ган кор рент ХХК-6910602

3) Юнит норм ХХК-8453675

4) Дижитал апекс ХХК-8461449

5) Айкер партнерс ХХК-6964133

6) Старлинк помад ХХК-8468699

7) Акок сохо ХХК-6725384

8) Арвижих датан ХХК-8478309

9) Да шин ХХК-9934618

10) Хос зика групп ХХК-6466095

11) Рийл мастэ ХХК-5331595

12) Өнгөт сор ХХК-8355711

13) Пэйпойнт солушнс ХХК-7003729

- 14) Бэрс эй би эс ХХК-8416052
- 15) Нар салхины энерги ХХК-5951542
- 16) Дүүлэн интернэшнл ХХК-7010081
- 17) Ничидо ХХК-8474435
- 18) Түшигтэй цогтой андууд ХХК-8429707
- 19) Атта эрхэс ХХК-8486522
- 20) МЛББ ХХК-5416353,

6. Зөрчлийн тухай хуулийн 10.17.2, 10.17.4, 10.17.8, 10.17.9 дугаар заалтын дагуу хялбаржуулсан журмаар 32 аж ахуй нэгж байгууллагад 16,5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулж СБД-н Прокурорын нэгдсэн бүртгэлд хугацаанд нь бүртгүүлж торгуулийг бүрэн барагдуулсан. Зөрчлийг хэрэг нээхээс татгалзсан тогтоол 5 байгууллагад гаргасан.

- 10.17.2-3 байгууллага-6,0 сая төгрөг
- 10.17.4-16 байгууллага-4,0 сая төгрөг
- 10.17.8-5 байгууллага- 5.0 сая төгрөг
- 10.17.9-3 байгууллага-1,5 сая төгрөг

нийт 16,5 сая төгрөгийн шийтгэлийн хуудсаар торгууль ногдуулсан.

- Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан тогтоол 4 байгууллагад улсын байцаагчийн актаар 8 даатгуулагчдад 63,9 сая төгрөгийн цалингын сангаас 15,2 сая төгрөгийн шимтгэлийг тооцож 7,6 сая төгрөгийн алданги ногдуулж нийт 22,8 сая төгрөгийн төлбөр зөрчлийг 100% барагдуулсан.

Орлого шимтгэлийн тасаг 1 зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан.

7. 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газраас явуулсан “Төрийн албан хаагчийн цахим ур чадварыг дээшлүүлэх” сургалтад хамрагдсан.

2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр Авлигатай тэмцэх газраас Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах тухай зөвлөмж болон бусад хуулиар явуулсан сургалтад хамрагдсан.

8. Сүхбаатар дүүргийн Засаг даргын захирамжаар 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 12 дугаар хорооны нийт нутаг дэвсгэр, Сэлбэ голын ойр орчимд цэвэрлэгээ хийж нийт 1 тонн хог цэвэрлэж ачуулав.

9. 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газартай хамтарсан Чойжин лхамын сүм музей-д зохион байгуулсан “Иргэнд үйлчлэх-Нээлттэй хаалга” өдөрлөгт оролцож Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн талаар зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

10. 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр Сүхбаатар дүүргийн Прокурорын газраас явуулсан Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн сургалтад хамрагдсан.

11. Газрын даргын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу “Шинэ албан хаагчдыг мэргэшүүлэх” сургалтад Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс

шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 10 удаагийн сургалтыг явууллаа.

12.Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газар, Сүхбаатар дүүргийн тамгын газрын хамтран хэрэгжүүлж буй Цэцэрлэгжилтийн аяны хүрээнд Газрын гадаах орчныг тохижуулж хашааг дагуулан мод тарьж, цэцгийн мандал байгуулж өнгө үзэмжийг сайжруулсан. Өрөө тасалгаанд стандартын дагуу үзэмжтэй сайхан савтай цэцэг тавьж тохижуулсан.

Тайлангийн хугацаанд бусад ажлыг Монгол Улсын нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох Тэтгэмжийн тухай хууль, бусад хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд болон салбарын харилцааг зохицуулж буй эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэхэд зохион байгууллалтын оновчтой хувилбараар ажиллахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд тус тасагт 147 хүсэлт ирсэн. И-Док-д 118 албан хүсэлт, 29 даатгуулагчийн нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл гомдол, хүсэлтийг хүлээн авч хүсэлт өргөдлийн дагуу хариуг нь хуулийн хугацаанд шийдвэрлэв.

- Зөрчлийн тухай хуулиар 32 аж ахуй нэгж байгууллага,

- Улсын байцаагчийн актаар байгууллага-44,

- Хяналтын картаар анхан шатны санхүүгийн баримтыг хянаж нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан цалин, шимтгэл ногдуулсан төрөл хувь хэмжээг залруулах хүсэлт 37 байгууллагын материалыг хянаж Орлого шимтгэлийн тасагт өгч залруулсан.

- Бусад мэдээ судалгаа, дүүргүүдийн нийгмийн даатгалын байгууллагаас ирүүлсэн хүсэлт, хүсэлтийн хариу зэрэг 4 албан бичиг ирсэн.

Нийгмийн даатгалын хууль болон бусад хууль тогтоомжтой холбоотой асуудлаар хяналтын бүх байцаагч гарын авлага болон судалгаатай болж ажиллаж байна.

НДЕГ болон газраас ирүүлсэн зөвлөмжийг өдөр тутмын ажилдаа мөрдлөгө болгон хэрэгжүүлж ажиллаж байна.

Газраас зохион байгуулсан цаг үеийн шинжтэй бүх үйл ажиллагаанд идэвхитэй оролцож өгсөн үүрэг даалгаваруудыг тухай бүрт нь биелүүлж ажилласан.

### **Дөрөв: Дүгнэлт, зорилт**

2023 онд олсон ололт амжилт, хүрсэн үр дүндээ тулгуурлан дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

- 1.Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийн төлөвлөгөөг биелүүлэн ажиллах.

- 2.Нийгмийн даатгалын үйл ажиллагааг гомдол чирэгдэлгүйгээр түргэн шуурхай явуулах, ажлын доголдол гаргахгүй ажиллах.

3.Ажлын хариуцлага санаачлагыг өндөржүүлж нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСАГ